



ДУНДГОВЬ АЙМГИЙН ОРОН  
НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ**

Засгийн газрын XII байр, 4 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170

Утас: (976-11) 31 06 12, 7600 3333-1126

Факс: (976-11) 32 29 04

Цахим шуудан: info@mcud.gov.mn

Цахим хуудас: www.mcud.gov.mn

2024.05.24 № 03/1683

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хөрөнгийн өмчлөлийн талаар**

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 231 дүгээр тогтоолоор Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713 төсөл”-ийн хүрээнд бий болсон 12,237,128,072.02 /арван хоёр тэрбум хоёр зуун гучин долоон сая нэг зуун хорин найман мянга далан хоёр төгрөг хоёр мөнгө/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан захиргаа-аж ахуйн барилга, сараалжийн болон хонгилын барилга, дэд өртөөний барилга, дренажийн насос станцын барилга, биоцөөрөм, гадна цахилгаан хангамж болон гэрэлтүүлэг, мөн Эрдэнэдалай сумын ус хангамж, ариутгах татуургын систем зэрэг хөрөнгийг орон нутгийн өмчлөлд бүртгэх зөвшөөрлийг олгосон.

Иймд уг тогтоолын 2 дахь заалтыг хэрэгжүүлэх хүрээнд холбогдох журмын дагуу орон нутгийн өмчит байгууллагын санхүүгийн тайланд бүртгэх шийдвэрийг гаргаж, хамтран ажиллахыг хүсье.

Хавсралт ...хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.БАЯРБАТ

152452770

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ТӨВ, ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ  
ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ ТОВЧОО**

1	АЖИЛ № 1.1-1.18, 6.13, 7.3-7.5 Захиргаа-аж ахуйн барилга	1,224,315,700.5
2	АЖИЛ № 2.1-2.11, 7.1, 18.1, 18.2 Сараалжийн барилга	222,210,235.00
3	АЖИЛ № 3.1-3.5, 6.10-6.12, 7.6, 15.4, 15.5 Хонгилын барилга	638,261,205.44
4	АЖИЛ № 4.1, 4.2, 6.15-6.17 Элс баригчийн барилга	134,492,420.11
5	АЖИЛ № 5.1, 5.2, 6.1-6.6, 6.14, 6.19, 7.2, 7.8, 18, 23.1, 23.2, 23.3, 23.4 Биологи цэвэрлэгээний блок	2,322,093,668.20
6	АЖИЛ № 6.18, 8.1, 14, 15.1, 15.3 Дренажны усны 40м <sup>3</sup> -ын цооног	97,393,462.00
7	АЖИЛ № 6.9, 9, 29.1, 29.2. Элс, лагийн талбай, лаг боловсруулах	769,402,848.53
8	АЖИЛ № 10. Зам талбай, хашаа	1,314,980,190.52
9	АЖИЛ № 11. Биоцөөрөм	124,635,896.00
10	АЖИЛ № 12. Цэвэр усны шугам	485,767,146.00
11	АЖИЛ № 13. Гадна дулааны шугам	60,625,700.00
12	АЖИЛ № 15.2, 16. Гадна бохир усны шугам	1,287,924,113.00
13	АЖИЛ № 17. Гадна гэрэлтүүлэг	51,247,596.00
14	АЖИЛ № 19.1, 19.2. 6 кВ-ын ЦДАШ	479,991,925.06
15	АЖИЛ № 20.1-20.4. 250 кВа трансформатор	101,966,282.00
16	АЖИЛ № 19.3. 04 кВ-ын кабель, генератор	133,920,817.50
17	АЖИЛ № 24. Эрдэнэдалай сумын УХАТ систем	1,939,828,243.31
18	АЖИЛ № 25. Механизм /Бохир усны авто машин, дунд хэмжээний авто ачигч/	296,571,815.99
19	АЖИЛ №26. Ус цэвэршүүлэх төхөөрөмж	266,978,161.34
20	АЖИЛ №27. Нэмэлт хөрөнгө	243,984,098.40
21	АЖИЛ № 28. Усны алдагдал илрүүлэх тоног төхөөрөмж	40,536,547.09
	<b>Дэд дүн</b>	<b>12,237,128,072.02</b>



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар 231

Улаанбаатар хот

Хөрөнгө, өр төлбөр бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Азийн хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр "Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн МОН-3713" төслийн хүрээнд бий болсон нийт 44,998,571,580.88 (дөчин дөрвөн тэрбум есөн зуун ерэн найман сая таван зуун далан нэгэн мянга таван зуун наян төгрөг наян найман мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгө, холбогдох өр төлбөрийг хавсралтад заасны дагуу аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Баярбат, Булган, Дундговь, Хэнтий, Хөвсгөл, Сүхбаатар аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Зээлийн хөрөнгөөр бий болсон үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, эзэмшигч байгууллагыг тогтоох, бүртгэлд тусгах асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2.Үл хөдлөх хөрөнгийн доорх газрын эзэмших эрхийг холбогдох орон нутгийн өмчит хуулийн этгээдийн нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.3.Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

132001126  
14-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2024 оны 05 дугаар сарын 16 ны өдрийн  
 831 дугаар тогтоолын хавсралт

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНКНЫ ЗЭЭЛИЙН ХӨРӨНГӨӨР "ЗҮҮН ӨМНӨД ГОВИЙН ХОТ БАЙГУУЛАЛТ, ХИЛИЙН ОЙРЛЦОО СУУРИН ГАЗРУУДЫН ХӨГЖЛИЙН МОН-3713" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИЙ БОЛСОН ХӨРӨНГИЙГ ОРОН НУТГИЙН ӨМЧИД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ (ТОВЧОО)

Д/д	Хөрөнгийн нэр	Нийт дүн (төгрөг)	Хүлээн авч бүртгэх орон нутгийн өмчит байгууллага	Сангийн яам, аймгийн Засаг даргатай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний огноо
1	Булган аймгийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	150,368,545.66	Булган аймгийн өмчит байгууллага	2019.08.29
	Дундговь аймгийн цэвэрлэх байгууламж	9,449,229,205.89		
2	Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын цэвэрлэх байгууламж болон бусад ажил	1,939,828,243.31	Дундговь аймгийн өмчит байгууллага	2019.08.29
	Машин механизм, багаж, тоног төхөөрөмж	848,070,622.82		
3	Хэнтий аймгийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	9,494,912,295.27	Хэнтий аймгийн өмчит байгууллага	2019.08.29
	Хэнтий аймгийн Бэрх сумын төвийн төвлөрсөн халаалтын систем	785,196,817.16		
	Машин механизм, багаж, тоног төхөөрөмж	519,124,022.72		
4	Бараа материал (Эргэлтийн хөрөнгө)	25,850,000.00	Хөвсгөл аймгийн өмчит байгууллага	2019.08.29
	Хөвсгөл аймгийн цэвэрлэх байгууламж болон бусад туслах үйлчилгээний ажлын хүрээнд бий болсон хөрөнгө	9,264,429,554.03		
	Машин механизм, багаж, тоног төхөөрөмж	1,015,810,947.26		

Д/д	Хөрөнгийн нэр	Нийт дүн (төгрөг)	Хүлээн авч бүртгэх орон нутгийн өмчит байгууллага	Сангийн яам, аймгийн Засаг даргатай байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний огноо
5	Сүхбаатар аймгийн төвийн цэвэрлэх байгууламж Машин механизм, багаж, тоног төхөөрөмж	10,429,913,360.11 1,075,837,966.65 44,998,571,580.88	Сүхбаатар аймгийн өмчит байгууллага	2019.08.29
Нийт дүн		(дечин дөрвөн тэрбум есөн зуун ерэн найман сая таван зуун далан нэгэн мянга таван зуун наян төгрөг наян найман мөнгө)	